

МӨРӨН СУМ



**МӨРӨН СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020.06.23



МӨРӨН СУМЫН АРДЧИЛСАН НАМААС 2020 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР.

НЭГ. ХӨГЖЛИЙГ БҮТЭЭХ МӨРӨНЧҮҮД /Хувь хүний хөгжил, эрх чөлөө/
Хан Хэнтий аймгийн иргэн бүрийг эрдэм боловсрол төгс, хөдөлмөрч, бүтээлч
сэтгэлгээтэй эрүүл амьдарлын хэв маягийг хэвшил болгосон, Монгол эх
орныхоо байгаль, түүх соёл, уламжлалаараа бахархсан өв тэгш хүмүүжлээр
төлөвшүүлэн хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний
хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

- 1.1 "Оюунлаг Мөрөнчүүд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.2 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, нутаг орныхоо байгаль,
түүх, соёл, уламжлалаараа бахархдаг "Зөв Монгол хүүхэд" дэд хөтөлбөрийг
хэрэгжүүлнэ.
- 1.3 "Багшийн хөгжил-Мөрөнгийн ирээдүй" дэд хөтөлбөрийг сумандаа
хэрэгжүүлнэ.
- 1.4 Боловсролын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах замаар сургууль
цэцэрлэгийн удирдах албан албан тушаалтаныг томилох, чөлөөлөхөд сумын
иргэдийн төлөөллөөс бүрдсэн "Боловсролын зөвлөл"-ийн саналыг үндэслэдэг
болно.
- 1.5 250 хүүхдийн багтаамж бүхий сургуулийн шинэ барилга барина.
- 1.6 Өндөр хөгжилтэй оронд сумын бодлогын дагуу оюутан болон албан хаагчдыг
сургаж мэргэшүүлнэ.
- 1.7 Сумын үйлдвэрлэлийн бодлоготой уялдуулан зах зээлийн хэрэгцээнд
нийцсэн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг аймгийн MCYT-д бэлтгэнэ.
- 1.8 Төрийн бодлогоор хэрэгжих "Түмэн инженер" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.9 Урьдчилан сэргийлэх үзлэгт суурилсан өндөр үр өгөөж бүхий эрүүл мэндийн
тогтолцоог сумын онцлогт тохируулан шинэчлэн хэрэгжүүлнэ.



1.10 Аймгийн эрүүл мэндийн салбарын бодлогын дагуу сумынхаа эмч нарыг өндөр хөгжилтэй орнуудад илгээн суралцуулж туршлагыг эзэмшүүлэн мэргэшүүлэх, замаар хорт хавдрын эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний чанарыг дээшлүүлнэ.

1.11 Сумын соёлын төвийн шинэ баилга барина.

1.12 Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээний зохион байгуулалтыг шинэчилж, үйлчилгээний чанар, хүртээмж шуурхай байдлыг эрс сайжруулна.

1.13 Архигүй Хэнтийчүүд-2 дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.14 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хэвшүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэн "Эрүүл мэндийг дэмжигч" сум болно.

1.15 Гэр бүлийн гишүүн бүрт ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжыг бий болгоно.

1.16 Сумы иргэдээ зээлийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хувийн орон сууцтай болгох тусгайлсан хөтөлбөр хэрэгжүүлж, ипотекийн 8 хувийн зээлийг хэрэгжүүлнэ.

1.17 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг шат дараалалтай хэрэгжүүлнэ.

1.18 Сумынхаа нэрийг тив, дэлхий, улсад өндөрт өргөсөн тамирчид, уран бүтээлчид, эрдэмтэд, алдартнуудыг сумын дэмжинэ.

1.19 Хэнтий нутгийн байгальд оршиж буй түүхийн дурсгалыг эзэнжүүлэн хамгаалж, тооллого бүртгэлийн мэдээллийн санг боловсронгуй болгоно.

ХОЁР. ӨСӨЛТИЙГ ХҮРТСЭН МӨРӨНЧҮҮД /Хүртээмжтэй эдийн засаг/

"Ажлын байр- Аймгийн хөгжил" чиглэлийг эрхэмлэн хөдөлмөрлөж, эдийн засгийн өсөлтийг өрх бүрээрээ хүртсэн бүтээгч Хэнтийчүүд , бусдад жишиг байх үзэл баримтлалыг мөрдөн ажиллана.

2.1 "Ажлын байр-Сумын хөгжил" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.2 Аймгийн гадаад харилцааны бодлогодоо эдийн засгийн түншлэл, худалдааны болон нийгмийн олон талт хэлэлцээрүүдийг байгуулан хэрэгжүүлнэ.

2.3 Технологийн дэвшлийг ашиглах замаар авилгыг мэдээлэх, илрүүлэх боломжийг бүрдүүлж бизнест учирдаг авилгын дарамтыг арилгана.

2.4 Сумандаа өрхийн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор төмс хүнсний ногоо, жимс жимсгэний үйлдвэрлэлийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлж хүлэмж , агуулах, зоориудын барьж байгуулна.

2.5 Уул уурхайн аливаа үйл ажиллагаанд нөхөн сэргээх, хөржүүлэн ургамалжуулах ажлыг гүйцэтгүүлэхийн зэрэгцээ дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагааг ашиглагчийн зайлшгүй гүйцэтгэх ажил болгоно.

23171
СЮА0048

Ганзоригийн



- 2.6 Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэсний дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ
- 2.7 "1000 өрх орон сууц" дэд хөтөлбөрийг сумандаа хэрэгжүүлнэ. / хаус хороолол, түрээсийн гэх мэт/
- 2.8 Сумын шуудан үйлчилгээний тогтолцоог шинэчлэн сайжруулна.

ГУРАВ. НУТАГТАА ЭЗЭН МӨРӨНЧҮҮД /Эзэн Монгол/

Бие даасан эдийн засагтай, эх орныхоо баялагаас хувь хүртсэн эдийн засгийн хувьд бие даасан, зөв засаглалд тэгш оролцож, түүх өв соёлоо эрэхмлэн дээдэлж нутагтаа эзэн хувь хүнийг төлөвшүүлнэ.

- 3.1 "Хашаандаа сайхан амьдаръя", "Жорлонгоо өөрчилье"дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.2 "Чинээлэг малчин"дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 3.3 Малчин өрхийн 6-8 настай хүүхдийг гэрээр сургах гэрийн сургалтын тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.4 Сумдын хилийн цэсийг тодотгон баталгаажуулах ажлыг хэрэгжүүлнэ.
- 3.5 Сумын төрийн өмчийн бүртгэл, ашиглалтыг сайжруулна.
- 3.6 Сумын төвийн төв замуудыг хатуу хучилттай болгон гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.

ДӨРӨВ:ХУУЛИЙГ ДЭЭДЛЭГЧ МӨРӨНЧҮҮД /Эзэн Монгол/

Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадавхитай засаг, хүн бүр ажил, албан тушаалаасаа үл хамаарч хуулийн өмнө хариуцлага хүлээдэг шударга шүүхийн тогтолцоо, мэргэжлийн хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлэх цогц шинэчлэл хийнэ.

- 4.1 Хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдийг дарамтлах , айлгах бус аюулгүй байдлын үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх , хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс онцгой анхаарна.
- 4.2 Аж ахуй эрхлэх, үйлдвэрлэлийг дэмжихэд холбогдох хууль, дүрэм, журмыг тогтвортой ойлгомжтой байх хууль зүйн цогц шинэчлэл хийнэ.
- 4.3 Татвар, төрийн хяналт шалгалтыг /мэргэжлийн хяналт /иргэн, хуулийн этгээдэд зөвлөх, боломж олгох, дэмжих чиглэлээр шинэчлэн зохион байгуулна.
- 4.4 Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргэдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.



44297
907408

4.3 Татвар, төрийн хяналт шалгалтыг /мэргэжлийн хяналт /иргэн, хуулийн этгээдэд зөвлөх, боломж олгох, дэмжих чиглэлээр шинэчлэн зохион байгуулна.

4.4 Авила, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж, нийтийн албаны үйл ажиллагааг иргээдэд ил тод, ялгамжгүй, шударга, хүртээмжтэй хүнд сурталгүй хүргэнэ.

4.5 Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, аюулгүй амар тайван амьдрах баталгааг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ авна.

4.6 Архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг эрчимжүүлж архидалт ,согтуурлын хор хөнөөлийг бууруулах ажлыг идэвхижүүлэнэ.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МӨРӨНЧҮҮД /Аюулгүй амгалан Монгол/

Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгын зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдарлын чанарыг сайжруулна.

5.1 "Ногоон сум" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.2 "Ногоон гудамж", "Иргэн бүр-Нэг мод" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.3 Сумын хэмжээнд байгаа гол, булаг, шанд, нуур, цөөрмийг хамгаалалтад авч байгалийн тэнцвэрт байдлыг хангана.

Хэнтий аймгийн Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг төлөөлж

/тэмдэг/ *Моролц* ...ыг төлөөлж
Увс албан тушаал

АРДЧИЛСАН НАМ
ХЭНТИЙ АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО
8488916 XHT1198

Ж.Ж.Балжан

/тэмдэг/ *Нарийн Чижев* б. Золбос ...ыг төлөөлж
албан тушаал гарын үсэг